

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хэсрэлт

ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ БАТМӨНХИЙН СОЛОНГЫН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. Салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах арга хэмжээний зохион байгуулалтыг хариуцна.							
1.	Арга хэмжээ 1.1. Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулна.	Хуулийн төсөл боловсруулалтын гүйцэтгэлийн хувь	40%	100%	Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр төслийг хэлэлцүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/13 дугаар тушаалаар байгуулан ажилласан бөгөөд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/45 дугаар тушаалаар бүрэлдэхүүнийг шинэчлэн дахин Ажлын хэсэг байгуулсан.	01-12	88%
1.1.	Дэд арга хэмжээ 1.1.1.Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг шинэчлэн байгуулна.	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0	5%		01	5%

1.2.	Дэд арга хэмжээ 1.1.2.Хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл боловсруулах, батлах эрх бүхий эмгээдэд хүргүүлнэ.	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0	20%	Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Барилга, хот байгуулалтын сайдтай хамтран батлахаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/163 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн ч Хууль зүй, дотоод хэргийн сайдаас хэд хэдэн үндэслэл дурдаж 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 1/849 дугаартай албан бичгээр үзэл баримтлалын төслийг батлахаас татгалзаж буцаасан. Буцаасан үндэслэлийн дагуу тайлбар бэлтгэж, Харилцаа холбооны зохицуулах хорооноос оруулсан санал дээр тайлбар бэлтгэж ирүүлэх талаар 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдөр цахим шуудангаар хүргүүлсэн боловч өнөөг хүртэл санал ирээгүй байна.	01	10%
1.3	Дэд арга хэмжээ 1.1.3.Хуулийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн зохион байгуулалтыг харууцна.	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0	20%	Хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг салбарын харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдүүд болон холбогдох бусад байгууллагын төлөөллийг хамруулан 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдөр Туушин зочид буудлын Соёмбо танхимд зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн гишүүд болон Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Монголын Цахилгаан холбоо ХК, Монгол шуудан ХХК, Мобиком корпораци ХХК, Скайтел ХХК, Юнител групп ХХК, Ондо ХХК, Ондо Холдинг ХХК, Мэдээлэл холбооны операторуудын ассоциаци, Монголын телевизүүдийн холбоо зэрэг байгууллагын 70 гаруй төлөөлөл оролцсоноос 11 байгууллагын төлөөлөл	03	20%

					хэлэлцүүлэг дээр санал гаргасан бол бусад байгууллагын төлөөлөл ОР бүртгэлийн хүрээнд цахимгаар саналаа ирүүлж оролцсон.		
1.4	Дэд арга хэмжээ 1.1.4.Хуулийн төсөлд санал авах ажлыг зохион байгуулна.	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0	20%	Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төсөл болон дагаж боловсруулсан 6 хуулийн төсөлд олон нийтээс санал авахаар байгууллагын цахим хуудас https://mddc.gov.mn/mn/%d1%85%83%d1%83%80%bb%d1%8c-%d1%8d%d1%80%d1%85-%d0%b7%d2%af%d0%b9/ -д 2024 оны 01 дүгээр сарын 23-аас 02 дугаар сарын 29-ний өдрийг дуустал хугацаанд байрлуулсан.	02-03	20%
1.5.	Дэд арга хэмжээ 1.1.5.Хуулийн төсөлд ирүүлсэн саналыг төсөлд нэгтгэн тусгана.	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0	30%	Байгууллагын цахим сүлжээнд нээлттэй байршуулсан хуулийн төсөлд 9 этгээдээс цахим шуудантаар болон албан бичгээр санал ирүүлснийг нэгтгэн боловсруулж хэлэлцүүлэгт танилцуулсан.	04	30%
1.6.	Дэд арга хэмжээ 1.1.6.Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо хийх гүйцэтгэчийг шалгаруулах ажлын зохион байгуулалтыг харуулна.	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0	5%	Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх, хуулийн төслийг баталснаар хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог боловсруулах ажлыг гүйцэтгэх этгээдийг нээлттэй шалгаруулахаар энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэгч 5 хуулийн этгээдэд 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 02/471 дугаартай албан бичгээр хамтран ажиллах саналыг хүргүүлснээс Оюуны-Инноваци ТББ, Хөгжлийн эрх зүйн төв ТББ-аас тус тус хамтран ажиллахаар үнийн санал ирүүлсэн. Ажлын хэсэг хуулийн төслийг эцэслэн хэлэлцээгүйн улмаас гүйцэтгэчийг сонгох ажил хойшлоод байна.	03-07	3%
2.	Арга хэмжээ 1.2. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний	Дүн шинжилгээ хийж боловсруулах хуулийн төслийн	0%	100%		02-03	85%

	хуулиар захирагчаны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалтад дүн шинжилгээ хийж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлнэ.	боловсруулалтын гүйцэтгэлийн хувь			Монгол Улсын Засгийн газрын 2023 оны хуралдааны 48 дугаар тэмдэглэлийг хэрэгжүүлж Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 191 дүгээр захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн хүрээнд яамдын Төрийн нарийн бичгийн дарга нарт хүргүүлсэн чиглэлийн дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний хуулиар захирагчаны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалтад дүн шинжилгээ хийх, тухайн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Дэд ажлын хэсгийг яам болон Харилцаа холбооны зохицуулах хорооны төлөөллийг оролцуулан байгуулсан.		
2.1.	Дэд арга хэмжээ 1.2.1.Ажлын хэсгээ байгуулна.	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	5%		02	5%
2.2.	Дэд арга хэмжээ 1.2.2.Захирагчаны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалтын судалгаа хийнэ.	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	30%	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Харилцаа холбооны тухай, Шуудангийн тухай, Радио долгионы тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Цахим гарын үсгийн тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Кибер аюулгүй байдлын тухай, Мэдээллийн технологийн үйлвэрлэлийг дэмжих тухай хуулиар захирагчаны хэм хэмжээний акт батлах эрхийг Засгийн газарт олгосон 37, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдад олгосон 43, Харилцаа холбооны зохицуулах хороонд олгосон 23, нийт 103 заалт, түүний дагуу баталсан Цахим	02	30%

					хөгжил, харилцаа холбооны сайд баталсан 51, Харилцаа холбооны зохицуулах хороо баталсан 46 хэм хэмжээний актад дүн шинжилгээ хийсэн.		
2.3.	Дэд арга хэмжээ 1.2.3.Цахим хөгжил, харилцаа холбооны сайдад эрх олгосон захираааны хэм хэмжээний актад дүн шинжилгээ хийх, ажлын хэсгийн хариуцсан ашиггүйн хамт холбогдох хуульд оруулах өөрчлөлтийн санал боловсруулна.	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	50%	Дэд ажлын хэсгийн хурлыг 2024 оны 02 дугаар сарын 19, 23, 26, 28-ны, 03 дугаар сарын 12, 26-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж, ажлын хэсгийн гишүүдийг холбогдох арга зүйн заавар, зөвлөмжөөр хангасан. Харилцаа холбооны зохицуулах хорооноос батлагдсан дүрэм, журмын хүрээнд хуульд өөрчлөлт оруулах санал бүхий тайланг цахимаар 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдөр, албан бичгээр 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр ируулсан. Шуудангийн тухай хууль, Радио долгионы тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулсан.	02-03	40%
2.4.	Дэд арга хэмжээ 1.2.4.Ажлын хэсгийн ашигүдээс ирүүлсэн мэдээллийг нэгтгэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай үзэл баримтлалтын төслийг боловсруулна.	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	10%	Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цахим гарын үсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулсан.	02-03	10%
2.5.	Дэд арга хэмжээ 1.2.5. Ажлын хэсгийн дүгнэлтийг нэгтгэн боловсруулах, удирдлагад манилцуулах, саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлнэ.	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	5%	Шуудангийн тухай хууль, Радио долгионы тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт	03	0%

				оруулах хуулийн төслийг хариуцсан албан хаагчдын хамт боловсруулсан.			
Зорилт 2. Хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах талаар зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ.							
3.	Арга хэмжээ 2.1. Салбарын бодлогын болон бусад баримт бичгийг холбогдох албан хаагчидтай хамтран шинэчлэн боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулахад арга зүйн зөвлөгөө өгнө.	Арга зүйн зөвлөгөө үзүүлж хамтран ажигласан журмын тоо	51	14	1.Тайлант хугацаанд “Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлал”, “Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам”, “Цагийн бүртгэл хөтлөх, аюулгүй байдлыг хангахад тавигдах шаардлага”, “Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”, “Домэйн нэрийн бүртгэлийн журам”, “Хөдөлмөрийн дотоод журам”, “Албан хаагчдын ажиглах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр”, “Цалин хөлсний журам”, Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан “Хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн ажиглах журам”-ын төсөл, “Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам”-ын төслийн боловсруулалтад холбогдох албан хаагчидтай хамтран ажигласан. 2.Мөн “Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудсыг ашиглах журам”, “Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон) ашиглалтын эрх зүйн орчныг бүрдүүлэх, туршилтын бүс байгуулах талаар авах арга хэмжээний тухай”, “Өргөн нэвтрүүлэг	01-12	100%

					хөгжүүлэх сангийн дүрэм, сан бүрдүүлэх, сангийн хөрөнгийг зарцуулах журамд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төслүүд болон холбогдох танилцуулга, Засгийн газрын гишүүдээс ирүүлсэн санал дээр ажилласан. 3.Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/05 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн хүрээнд Виртуал бүсийн зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн ажиллах журмын төслийг батлах талаарх Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төслийг хянаж засварласан. Мөн “Виртуал бүсийн ажиллах журам”-ын төслийг мэдээллийн технологийн компанийн төлөөлүүдээр хэлэлцүүлэх нээлттэй хэлэлцүүлгийг Мэдээлэл технологийн үндэсний парктэй хамтран 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаар уг зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн ажиллах журмыг хэлэлцэн баталсан. 4.Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгуулахаар тус яамнаас Дэлхийн шуудан холбооны дүрмийн арваннэгдүгээр нэмэлт протоколыг соёрхон батлах тухай, Шуудангийн тухай хууль (Шинэчилсэн найруулга), Сансрын тухай хууль (Анхдагч хуулийн төсөл), Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ийн тухай хууль (Анхдагч хуулийн төсөл), Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хариуцан боловсруулах талаар саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 01/344 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.		
--	--	--	--	--	---	--	--

					5. Шуудангийн үндсэн сүлжээ ашиглах эрх олгох, хяналт тавих журам"-ын төсөл, Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгад яамдаас өмнө ирүүлсэн саналыг тусган Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан Засгийн газрын гишүүдээс дахин санал авахаар 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 01/406 дугаартай албан бичгийг 20 газарт хүргүүлсэн.		
4.	Арга хэмжээ 2.2. Сайд, Төрийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээнд гаргасан шийдвэртэй холбогдох эрх зүйн маргааныг хууль, шүүхийн байгууллагаар хянан шийдвэрлэх ажиллагаанд байгууллагын эрх ашгийг хамгаална.	Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон хэргийн тоо	3	3	1. Монголсат нэтворкс ХХК-аас 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргасан "Сансрын холбооны Кэй Юу зурвасын технологи ашиглан телевизийн олон сүвгийн нэвтрүүлгийг орон даяар дамжуулах үйлчилгээ үзүүлэх" ХХИТГ/201911001 дугаартай гэрээний үүргийн гүйцэтгэлд 2,002,500,000 төгрөгийг нэхэмжилсэн иргэний хэргийг шүүхээр хянан шийдвэрлэхэд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажилласан. Шүүхээс 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдөр хэргийг хянан хэлэлцэж гэрээний хүрээнд захиалагч, гүйцэтгэгч нарын хооронд 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан нэмэлт гэрээг хүчин төгөлдөрт тооцож, нэхэмжлэлийн шаардлагаас алданти 150,000 төгрөгийг хэрэгсэхгүй болгож үлдэх төлбөрийг тус яамнаас гаргуулахаар шийдвэрлэсэн. 2. Ондо ХХК-аас 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргасан Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн А/37 дугаар тушаал, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 94 дүгээр тогтоолоор тус тус баталсан захиргааны хэм хэмжээний актын зарим хэсгийг хүчингүй болгуулах нэхэмжлэлтэй	01-12	100%

					захиргааны хэргийг шүүхээр хянан шийдвэрлэхэд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллаж байна. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн хуралдаан 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдөр болсон бөгөөд хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой гэж үзэж Гадаад харилцааны яамнаас "Олон Улсын цахилгаан холбооны байгууллагад Монгол Улс гишүүнээр элсэн орсонтой холбогдох дагаж мөрдөх олон улсын гэрээ, конвенц"-ийг шүүхийн журмаар гаргуулах хүсэлтийг гаргаад байна. Уг хэргийг шийдвэрлүүлэхэд Сансрын холбооны хэлтэс, Харилцаа холбооны Зохицуулах хорооны Радио давтамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газартай хамтран ажиллаж байна. 3. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын үйлчилгээний нэгдсэн төвийн зохицуулалтын газрын Сүхбаатар аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн даргаар ажиллаж байсан Р.Алтаннараас 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргасан "Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн Б/25 тоот тушаалын дагуу төрд ажилласан жилийн нэмэгдэл, цалин, ажилгүйдлийн тэтгэмж нийт 7,636,000 төгрөгийг гаргуулах, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын дэвтэрт нөхөн бичилт хийлгэх нэхэмжлэлтэй иргэний хэргийг шүүхээр хянан шийдвэрлэхэд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажилласан. Шүүхээс 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хэргийг хянан хэлэлцээд нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.		
--	--	--	--	--	---	--	--

5.	Арга хэмжээ 2.3.Хуулийн төсөл, Улсын Их хурлын тогтоолын төсөл, Засгийн газрын тогтоолын төсөлд санал боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх	Санал өгсөн хууль, зарлиг, журам, тогтоолын төслийн тоо	31	-	Тайлант хугацаанд 115 албан бичиг удирдлагаас цохолттой ирснээс шийдвэрлэсэн шийдвэрлэсэн 100, судлагдаж байгаа 15 албан бичиг байна. Үүнээс 30 хууль, журмын төсөлд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын саналыг хүргүүлсэн.	01-12	100%
6.	Арга хэмжээ 2.4. Албан хаагчдад шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаар мэдээллийг тухай бүрд өгөх, шаардлагатай сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.	Зохион байгуулсан танхимын сургалтын тоо	3	2	"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагчийн шийдвэр гаргах ажиллагаа" болон "Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдэгдэл, тайлбар гаргах асуудлын талаар" тус тус сургалт зохион байгуулахаар бэлтгэсэн.	07-12	70%
Зорилт 3. Сайд, Төрийн нарийн бичгийн даргын шийдвэрийн эрхзүйн үндэслэлийг хангуулах, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл дэмжлэгээр хангана.							
7.	Арга хэмжээ 3.1. Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын эрх зүйн үндэслэлийг хангуулна.	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	-	100%		01-12	100%
7.1.	Арга хэмжээ 3.1.1.Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын төслийн эрх зүйн үндэслэлийг хянаж, хууль тогтоомжид нийцүүлэх	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	70%	Үйл ажиллагаатай холбоотой сайдын 135, Төрийн нарийн бичгийн даргын 331, хүний нөөцтэй холбоотой сайдын 61, Төрийн нарийн бичгийн даргын 169 тушаалын эрх зүйн үндэслэл, найруулгыг хянаж засвар оруулсан. Мөн 85 тушаалыг харуулсан албан хаагчид боловсруулж өгсөн.	01-12	70%
7.2.	Арга хэмжээ 3.1.2.Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын бүртгэл хөтлөх	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	5%	Үйл ажиллагаатай холбоотой сайдын 135, Төрийн нарийн бичгийн даргын 331, хүний нөөцтэй холбоотой сайдын 61, Төрийн нарийн бичгийн даргын 169 тушаалд дугаар олгож, боловсруулсан албан хаагчид хувийг хүргүүлсэн.	01-12	5%
7.3.	Арга хэмжээ 3.1.3.Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын цахим хувийг үүсгэх, байгууллагын дотоод сүлжээнд байрлуулах	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	10%	Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалыг баталгаажсанаас хойш 7 хоногийн дотор скайнердаж цахим хувийг байгууллагын дотоод удирдлагын системийн файлын санд албан хаагч танилцах боломжоор хангаж байрлуулж байна.	01-12	10%

7.4.	Арга хэмжээ 3.1.4.Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалыг архивт шилжүүлэх	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	15%	Цахим хөгжиж, харилцаа холбооны сайд, Төрийн нарийн бичгийн даргын нийт 606 тушаал 2023 онд батлагдсаныг архивын нэгж болгон цаасан болон цахим хувь бүхий 25 боть материалыг Архив, бичиг хэргийн мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.	03	15%
Зорилт 4. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулна.							
8.	Арга хэмжээ 4.1. Нийтийн албан тушаалтны 2023 оны хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгийн тайланг Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ.	Тайлангийн гүйцэтгэлийн хувь	-	100%		01-02	100%
8.1.	Арга хэмжээ 4.1.1.Тус яамны болон харьяа байгууллагын нийтийн албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчдын жагсаалтыг нэгтгэж Авлигатай тэмцэх газрын харуусан ЭБАТ-д хүргүүлэх	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	15%	Нийтийн албан тушаалтны 2023 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг шинэчлэн гаргуулах эрхийг мэдүүлгийн бүрдүүлэлтийн системд нээсэнтэй холбогдуулан тус яамны болон харьяа байгууллагын 125 мэдүүлэг гаргагчийн мэдээллийг 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 03/57 дугаартай албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.	01	15%
8.2.	Арга хэмжээ 4.1.2.Мэдүүлгийн бүрдүүлэлтийн системд мэдүүлэг гаргавал зохих албан хаагчийн эрхийг үүссэн эсэхийг шалгах, давхар үүссэн эрхийг устгах	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	5%	Тухайн жилд нэгж хооронд шилжин томилогдсон, хуухэд асрах чөлөө авсан, ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчийн бүртгэл мэдүүлгийн бүрдүүлэлтийн системд шинэчилсэн мэдүүлэг гаргах эрх үүсгэхэд давхардаж үүсдэг бөгөөд нарийн жагсаалтад орсон албан хаагч бүрээр тулгаж давхардсан бүртгэлийг устгасан болно.	01	5%
8.3.	Арга хэмжээ 4.1.3.Албан хаагчид болон салбар ЭБАТ-д мэдүүлэг гаргах талаарх арга зүйн заавар, зөвлөсөөг өгөх, сургалт зохион байгуулах	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	20%	Шинэчилсэн мэдүүлэг гаргахтай холбогдуулан яамны албан хаагчдад 2024 оны 1 дүгээр сарын 04-ний өдөр албаны цахим шуудантаар, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар болон харьяа 4 улсын төсөвт үйлдвэрийн газрын Эрх бүхий албан тушаалтнуудад 2024 оны 1 дүгээр сарын 08-ны өдөр танхимаар сургалт орж мэдүүлэг	01	20%

					гаргахтай холбоотой заавар, зөвлөгөөт өгсөн.		
8.4.	Арга хэмжээ 4.1.4. Хуулийн хугацаанд гаргасан мэдүүлгийг шалган баталгаажуулах, ЭБАТ-ын бүртгэл хөглөх	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	40%	Тус яамны мэдүүлэг гаргавал зохих 70 албан хаагчийн гаргасан мэдүүлгийг тухай бүрд шалган, холбогдох заавар зөвлөмжөөр хангаж, мэдүүлгийн бүрдүүлэлтийн системд баталгаажуулсан.	01	40%
8.5.	Арга хэмжээ 4.1.5. Мэдүүлгийн бүрдүүлэлтийн системээс татсан тайланг хянан холбогдох засварыг оруулах, удирдлагаар баталгаажуулж, Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	20%	Тус яам болон яамны харьяа байгууллага (Үндэсний дата төв УТҮГ, И-Монгол академи УТҮГ, Радио, телевизийн үндэсний сулжээ УТҮГ, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ)-ын албан хаагчдын "Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн 2023 оны тайлан"-г мэдүүлгийн бүрдүүлэлтийн системд баталгаажуулан, нэгтгэсэн тайланг 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 03/348 дугаартай албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.	02	20%
9.	Арга хэмжээ 4.2. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнана.	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	100%		01-12	80%
9.1.	Арга хэмжээ 4.2.1. Авлигын эсрэг сүлжээнд байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг баталгаажуулах	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	25%	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг 3 зорилтын хүрээнд 11 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн Авлигын эсрэг сүлжээ цахим систем http://khubidubug.iaac.mn/iaac/humanadmind/login/?cookie=http%3A%2F%2Fkhubidubug.iaac.mn%2Fiaac%2Fhome%2F- д баталгаажуулсан. Цаасан хувийг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан.	05	25%
9.2.	Арга хэмжээ 4.2.2. Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон түүний харьяа байгууллагуудын авлигын эрсдэлийн үнэлгээг хийх ажлын гүйцэтгэлд дэмжлэг үзүүлэх	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	15%	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/38 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2024 оны худалдан авах ажиллагааны	05-12	15%

					төлөвлөгөө", тус яамны авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон түүний харьяа байгууллагуудын авлигын эрсдэлийг үнэлэх", "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон түүний харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлсэн эсэхэд дүгнэлт гаргах" ажлыг хөндлөнгийн, хараат бус этгээдээр гүйцэтгүүлж байна.		
9.3.	Арга хэмжээ 4.2.3. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулахад бусад нэгжтэй хамтран ажиллах, тайлагнах	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	60%	Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг нэгтгэн 2024 оны 12 сард багтаан Авлигын эсрэг сүлжээ / http://kpi.tyubig.iac.mn/ цахим санд тайлагнахаар ажиллаж байна. Авлигатай тэмцэх газраас 2 жил тутам зохион байгуулдаг төрийн байгууллагын "Шударга байдлын үнэлгээ" судалгаанд 30 албан хаагч, бодлого шийдвэр гаргахад оролцдог хамтран ажилладаг эрдэмтэн, судлаачдын төлөөлөл 30 хүнийг судалгаанд хамруулсан.	12	40%
10.	Арга хэмжээ 4.3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан тус яамнаас хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн тайлагнана.	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	100%		01-12	90%
10.1.	Арга хэмжээ 4.3.1. Хөтөлбөрт туссан тус яамнаас хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээг ялгаж, хариуцсан нэгжийн удирдлагад танилцуулах	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	-	20%	Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, 2024 оны 46 дугаар тогтоолоор баталсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тус яамнаас үндсэн болон хамтран хариуцагчаар ажиллахаар туссан 22 арга хэмжээг жил жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх зохион байгуулалтыг хийж ажиллах чиглэлийг Авлигатай тэмцэх	01-02	20%

					газраас ирүүлснийг 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр нийт албан хаагчдын цахим шуудангаар хүргүүлж танилцуулсан. Мөн тус яамнаас үндсэн хэрэгжүүлэгчээр ажиллах 4 арга хэмжээг яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нэмэлтээр тусгасан талаарх мэдээллийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 03/415 дугаартай албан бичгээр тус тус Авлигатай тэмцэх газрын хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжид хүргүүлсэн.		
10.2.	Арга хэмжээ 4.3.2. Арга хэмжээний хэрэгжилтийг жил бүрийн 01 сард багтаан тайлагнаж, тайланг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	-	80%	"Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн 2.5.3-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэхтэй холбоотой тус яамнаас хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээллийг И-Монгол академи УТГ-аас гаргуулж, 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 03/279 дугаартай албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Түүнчлэн тус яамнаас хариуцан, хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтыг хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөнөөс шууж, хэрэгжилтийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нэгтгэн Авлигатай тэмцэх газрын Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгжид цахим шуудангаар хүргүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг нэгтгэн 2025 оны 01 сард багтаан Авлигын эсрэг сүлжээ цахим системд тайлагнахаар ажиллаж байна.	07-12	70%
11.	Арга хэмжээ 4.4. Албан тушаалтнаас гаргасан ашиг сонирхлын зөрчил үүссэн, зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл тайлбарыг шилэн дансны, мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системд бүртгэнэ.	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	-	100%		01-12	100%

11.1.	Арга хэмжээ 4.4.1. Албан тушаалтнаас гаргасан ашиг сонирхлын зөрчил үүссэн, зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл, тайлбарыг сканердаж цахим архив үүсгэх	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	-	60%	Албан хаагчаас ирүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүрд сканердаж цаасан болон цахим архивын нэгж үүсгэж байна.	01-12	60%
11.2.	Арга хэмжээ 4.4.2. Албан тушаалтнаас гэрээ байгуулах, хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө гаргасан ашиг сонирхлын зөрчил үүссэн, зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл, тайлбарыг шилэн дансны системд бүртгэх	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	-	10%	Тус яамнаас хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэчийг шалгаруулах, бусад аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулах гэрээний төслийг боловсруулах, гэрээг байгуулах, батлахад гаргасан 52 мэдэгдэл, тайлбарыг хуулийн хугацаанд багтаан Шилэн дансны системд бүртгэсэн.	01-12	10%
11.3.	Арга хэмжээ 4.4.3. Албан тушаалтнаас захираганы шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө гаргасан ашиг сонирхлын зөрчил үүссэн, зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл, тайлбарыг мэдүүлгийн бүрдүүлэлтийн системд бүртгэх	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	-	30%	Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажиллах, хяналт шалгалтаар ажиллах, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулахад нийтийн албан тушаалтнаас гаргасан мэдэгдэл, тайлбарыг мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системийн ЭБАТ цэсэд улирал бүр бүртгэж байна.	01-12	30%
12.	Арга хэмжээ 4.5. Албан хаагч шилжин болон сэлтэн томилогдох, шинээр томилогдоход мэдүүлгийг хянуулах хүсэлтийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ.	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	-	100%	Авлигатай тэмцэх газраар нэгж хооронд шилжин томилох 5, шинээр томилох 18, хавсран ажиллуулах 2, ээгүй албан хаагчийн оронд түр орлон гүйцэтгэгчээр томилох 21 иргэн, албан хаагчийн хувийн ашиг сонирхлын байдлыг хянуулахаар эрхийг мэдүүлгийн бүрдүүлэлтийн системд үүсгэж, заавар зөвлөмжийг цахим шуудангаар нь хүргүүлж ажилласан.	01-12	100%
12.1.	Арга хэмжээ 4.5.1. Мэдүүлгийн бүрдүүлэлтийн системд албан хаагч, иргэний хувийн ашиг сонирхлын байдлаа мэдүүлэх эрхийг үүсгэх, зөвлөгөө өгөх	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	-	40%		01-12	40%

12.2.	Арга хэмжээ 4.5.2.Албан хаагч, иргэний хувийн ашиг сонирхлын байдлыг хянуулах хүсэлтийг боловсруулан баталгаажуулж, Авлигатай тэмцэх газарт бүрдэл ханган хүргүүлэх	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	-	30%	Тайлант хугацаанд нийт 51 албан хаагч, иргэний хувийн ашиг сонирхлын байдлыг хянуулах хүсэлтийг 36 удаагийн албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.	01-12	30%
12.3.	Арга хэмжээ 4.5.3.ХАСУМ-ийн бүртгэлийг бүрдүүлэлтийн системийн ЭБАТ цэсэд хөтлөх	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	-	30%	Иргэнийг шинээр томилох, албан хаагчийг шилжүүлэн томилоход гаргасан хувийн ашиг сонирхлыг хянасан дүгнэлт болон томигсон талаарх шийдвэрийг улирал бүр мэдүүлгийн бүрдүүлэлтийн системийн ЭБАТ цэсэд бүртгэж байна.	01-12	30%

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Яамны үйл ажиллагааны хүрээнд Сайдын, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын төсөлд хяналт шинжилгээ хийхэд дэмжлэг үзүүлэх	Тушаалын төслийг Хяналт Шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн байх	-	-	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас ирүүлсэн 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 06 дугаар дотоод албан бичгийн дагуу дор дурдсан баримтыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мөргөжилтэн М.Мөнхтуулд 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр хүлээлгэн өгөв: 1.цахим хэлбэрээр: Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн "Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын болон Төрийн нарийн бичгийн даргын А тушаалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" А/189 дүгээр тушаалд хамаарах Сайдын болон Төрийн нарийн бичгийн даргын А тушаал-нийт 37 тушаал, Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны IV улиралд гарсан А тушаал-нийт 83 тушаал, Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны I улиралд гарсан А тушаал-нийт 62 тушаал.	01-05	100%

					2. цаасан хэлбэрээр: Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын болон Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны I улиралд гарсан А тушаалын төсөл архивын 3 боть.		
2.	Байгууллагын олон нийтийн арга хэмжээнд оролцох	Оролцоог хангасан байх	-	-	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн "Бүх нийтийн мод тарих үндэсний өдөр"-ийн хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэр Түргэний гол дагуух "Ногоон хэрэм" зурваст мод тарих үйл ажиллагаанд оролцож 20 суулгац суулгасан.	01-06	100%
3.	Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/49 дүгээр тушаалаар байгуулсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллах	Харуцсан нэгжийн чиг үүргийг төсөлд тусгасан байх	-	-	Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд 2024-2028 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөний төсөл боловсруулах Ажлын хэсгийн хүрээнд төлөвлөгөөний төсөлд төрийн захиргааны удирдлага, манлайллыг хангах, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой зорилт, арга хэмжээний төслийг боловсруулан тусгасан. Мөн Ажлын хэсгийн нарийн бичиг Ахлах шинжээч Б.Эрдэнэтэй баримт бичгийн төсөл дээр ажилласан.	03-05	90%
4.	ХХМТГ/201911001 дугаартай гэрээний гүйцэтгэгчтэй гэрээг 2024 онд сунгах нөхцөлийг харилцан тохиролцох уулзалтын зохион байгуулалтыг харууцах	Уулзалтын тэмдэглэлийг албажуулах	-	-	"Сансрын холбооны Кэй Юу зурвасын технологи ашиглан төлөвзийн олон сувгийн нэвтрүүлгийг орон давар дамжуулах үйлчилгээ үзүүлэх" ХХМТГ/201911001 дугаартай гэрээг хэрэгжүүлэх хүрээнд Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 128/ШШ2023/0715 дугаартай шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 221/МА2023/700 дугаартай магадлал, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 182/ШШ2024/01246 дугаартай шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан талуудын хооронд байгуулсан ХХМТГ/201911001 дугаартай гэрээ, гэрээнд 2022 оны 02 дугаар сарын 09-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу гэрээг 2024 онд сунгах төслийг боловсруулж, талуудаар гэрээг батлуулах зохион байгуулалтыг хийсэн. Мөн Монголсат Нэтворкс ХХК-тай 2024 оны 04 дүгээр сарын 17, 22-ны өдөр хийсэн уулзалтын тэмдэглэлүүдийг хөтөлж, баталгаажуулан Төрийн нарийн бичгийн дарга, Сайдад танилцуулан баталгаажуулсан.	04	100%

5.	Салбарт ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагын мэдээллийг гаргах	Эх сурвалж бүхий мэдээлэл гаргасан байх	-	-	Төрийн захирагчааны удирдлагын газрын даргаас чиглэл өгсний дагуу салбарын төрийн бус байгууллагын мэдээллийг orendata.laib.mn , orendata.bytigel.gov.mn системээс хайлт хийж 17 байгууллагын мэдээллийг нэгтгэн танилцуулсан.	04	100%
6.	Яам өөрчлөн байгуулагдсантай холбогдуулан зарим бэлтгэл ажлыг хангах	Албан бичгүүдийн төслийг боловсруулсан.	-	-	Тус яам нь Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай, Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн тогтоолын дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болж өөрчлөгдсөнтэй холбогдуулан хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэх, тамга, тэмдэг хийлгэх зөвшөөрөл авах хүсэлтийг боловсруулан 2024 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 03/1412, 03/1417 дугаартай албан бичгээр тус тус Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн.	07	100%
7.	Яам өөрчлөн байгуулагдсантай холбогдуулан зарим бэлтгэл ажлыг хангах	Хөтөлбөрийн төслийг боловсруулсан байх	-	-	"Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын тогтоолын төсөлд санал авах бичгийг Засгийн газрын гишүүдэд 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 01/103 дугаартай албан бичгээр хүргүүлж санал ирүүлсэн 13 сайдын саналыг нэгтгэн тусгаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх хүсэлтийг 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 01/162 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.	08-09	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		
	1	2	3	4	5	6	7

1.	Арга хэмжээ 1. Удирдлагын зохион сургалтад хамрагдана.	Суралцсан кредит цаг	16	-	Захиалгат сургалтын квотод хамрагдаагүй болно.	07-12	-
2.	Арга хэмжээ 2. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулах Эрх бүхий албан тушаалтныг чадавхжуулах сургалтад хамрагдана.	Хамрагдах сургалтын тоо	3	3	1.Тус яамнаас сургалт авахаар гаргасан хүсэлтийн дагуу Авлигатай тэмцэх газраас "Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх" хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан цахим сургалтад яамны 40 албан хаагч болон харьяа УТҮГ-ын албан хаагчдыг хамруулсан. 2.Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн Байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор "Хөрөнгө, орлогын мэдүүлэг болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг бүртгэх, хянах, хадгалах журам" болон холбогдох маягууд, мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалтыг шинэчлэн баталсантай холбогдуулан Авлигатай тэмцэх газраас 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан арга зүйн заавар өгөх цахим сургалтад харьяа 4 улсын төсөвт үйлдвэрийн газрын ЭБАТ-уудын хамт хамрагдсан. 3. Авлигатай тэмцэх газраас 2024 оны 06 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд зохион байгуулсан "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургагч багш бэлтгэх сургалт"-д хамрагдсан. Мөн Авлигатай тэмцэх газрын зүгээс бэлтгэсэн сургагч багш нарын цахим уулзалтад 2024 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр хамрагдсан.	01-12	100%
3.	Арга хэмжээ 3. Албан хаагчдын үр чадаар, чадавхыг хөгжүүлэх байгууллагын дотоод сургалтад хамрагдана.	Хамрагдах сургалтын тоо	2	7	Сангийн яамны Хууль, эрх зүйн газраас зохион байгуулсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг танилцуулах сургалтад 2024 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр, "Рациональ сэтгэлгээ буюу бодож сурах нь" сэдэвт сургалтад 2024 оны 2 дугаар сарын 07-ны өдөр, ЕЕР систем ашиглан албан бичиг боловсруулах талаар "Цахим албан бичгийн боловсруулалт" сэдэвт сургалтад 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр, Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас зохион байгуулсан "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах" сургалт болон дадлагад 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр, яамны хөдөлмөрийн дотоод журамд өөрчлөлт оруулж байгаагай холбогдуулан Төрийн захирааны	01-12	100%

				Удирдлагын газраас зохион байгуулсан цахим сургалтад 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр, "Байгууллагын зохион байгууллагын бүтцийн чиг үүрэг, ажлын байрны дүн шинжилгээ", "Нийгмийн сүлжээн дэх эрх зүйн зохицуулалт", "Хэвлэлийн өөрийн зохицууллагын туршлага" /Герман Улс болон бусад орны сайн туршлагаас/ зэрэг сэдвээр "Хэвлэл мэдээллийн зөвлөл", "Авуурьд Ананд" НҮТББ-тай хамтран зохион байгуулсан сургалтад 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зохион байгуулсан "Хууль тогтоомжийн төсөл, захиргааны хэм хэмжээний актын төсөл болон бодлогын баримт бичиг боловсруулахад анхаарах асуудал" сэдэвт сургалтад 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр тус тус хамрагдсан. Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн Байнгын хорооноос 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан "Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилт, боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага" сэдэвт хэлэлцүүлэгт яамдын Хуулийн хэлтсийн төлөөлөл, ШЕЗ, Хуульчдын холбоо, Улсын Дээд Шүүх, ХЗҮХ-ийн төлөөлөл оролцсон бөгөөд хуулийн хэрэгжилтийн хүрээнд гарч байгаа асуудалд саналаа илэрхийлсэн. Улсын Их Хурлын Тамгын газраас 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулсан "Шинэ үеийн парламент: Турван төгөлдөршил" сэдэвт хэлэлцүүлэгт хэлтсээрээ оролцсон. Төрийн албаны зөвлөлөөс тус яаманд хийсэн хүний нөөцийн аудитын шалгалтын хүрээнд Төрийн албаны Салбар зөвлөлийн гишүүдийг хамруулсан тусгай шалгалт зохион байгуулах талаарх зөвлөмж өгөх сургалтад хамрагдсан.		
--	--	--	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

ШИНЖЭЭЧ
(Албан тушаал)

Б.СОЛОНГО / *Биемо* /
(Нэр, гарын үсэг)

2024.12.05
(Огноо)